



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/154

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулагдах газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Цэдэв- Хууль, эрх зүйн хариуцсан мэргэжилтэн
Дуудлага худалдааны хөтлөгч: Ц.Нямдорж-Газрын даамал
Тэмдэглэл хөтлөгч: Д.Мөнхбат- Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн дарга /Л.Цэдэв /-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-ын дагуу тогтоож, зохих журмын дагуу Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар дуудлага худалдааг зохион байгуулах.

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15,1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ